


Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2019 оны А/634 тоот тушаалын хавсралт

БАТЛАВ



“ЭКО АСФАЛЬТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2023 оны 05 сарын 15-ны өдөр

Дугаар 10/18

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу Туул голын сав газрын захиргааны гаргасан 2022 оны 12-р сарын 12-ны өдрийн ХУД 22/130 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Ганболд овогтой Туяацэцэг, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, ТЭЦ 3-ын баруун талд байрлах 9011571011 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 6001769 тоот регистрийн дугаартай “Эко асфальт” ХХК-ийг төлөөлж захирал Д.Батболд нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татгуурын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 6561:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын нормтив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын нормтив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харъяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.3.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.3.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;